2026 оны 4-р сарын 17

ХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭСЭН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан "Хууль бусаар мод бэлтгэх" гэмт хэргээр 2025 онд 217 хүнд холбогдох 190 хэрэгт, 2026 оны I улирлын байдлаар 38 хүнд холбогдох 35 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлэсэн байна.

Ойн тухай хуульд зааснаар арчилгаа, цэвэрлэгээ, үйлдвэрлэлийн ашиглалт гэсэн гурван зориулалтаар зөвшөөрөлтэйгөөр зөвхөн огтлолтоор мод бэлтгэхийг хууль ёсны гэж үзэх бөгөөд гэрээ, зөвшөөрөлгүй, эсхүл зөвшөөрсөн тоо хэмжээнээс хэтрүүлж мөн зориулалт, бэлтгэх арга, технологийг зөрчиж мод бэлтгэснийг хууль бусаар мод бэлтгэсэн гэж үзнэ.

Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "зөвшөөрөлгүй мод бэлтгэх" гэдэгт ой, ойн сан бүхий газарт ургасан модыг зохих зөвшөөрөлгүйгээр шууд санаатай, шунахайн сэдэлтээр халдаж, хөрөөдөх, тастах, цагаалах зэрэг огтлох үйлдлээс гадна модыг технологийн бус аргаар тухайлбал, үндэстэй нь хөрснөөс

сугалах, булгалах зэргээр газрын гадарга, хүрээлэн буй орчноос салган авч ойн санг бүрдүүлэгч хүчин зүйлийн даац чадавхид хохирол учруулсан, төлөв байдлыг доройтуулсан аливаа сөрөг үйлдэл хамаарна.

Архангай аймгийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсэн хэргийн талаар тоймлон хүргэж байна.

- Ч.П нь 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Архангай аймгийн Булган сумын Зүрх уулаас зохих зөвшөөрлийн бичиггүйгээр 6 ширхэг шинэс мод хууль бусаар бэлтгэсэн хэрэгт Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн. Шүүхээс Ч.П-г гэм буруутайд тооцож, 900 мянган төгрөгийн торгох ял оногдуулж, гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгсэл, цахилгаан хөрөө, хураагдсан шинэс моднуудыг улсын орлого болгож, ойн санд учирсан хохирлыг 3 дахин нэмэгдүүлж, 1 сая төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлэсэн.

> Иргэн уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон ахуйн хэрэглээний хэрэгцээнд ойгоос мод бэлтгэхдээ Ойн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад зааснаар мод бэлтгэх хүсэлтээ ойн анги, эсхүл тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагчид гаргаж шийдвэрлүүлэх журамтай болохыг Прокурорын байгууллагаас анхааруулж байна.

Манай улсын нийт нутаг дэвсгэрийн 8.2 хувийг ойн сан бүхий газар эзэлж, нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртөөд байгаа тул иргэд та бүхэн Монгол Улсын Үндсэн хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар хүлээсэн “Байгалиа хамгаалах” журамт үүргээ биелүүлэхийг уриалж байна.

Эх сурвалж: https://arkhangai.prosecutor.mn/post/269